

**Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн  
найруулгын төслийн үзэл баримтлал**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хууль зүйн болон практик шаардлага байгааг дараах үндэслэлээр тайлбарлаж байна.

Хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл:

1. Валютын зохицуулалтын тухай хууль нь 1994 оны 5 дугаар сарын 12-ны өдөр УИХ-аар батлагдсанаас хойш 22 жилийн хугацаанд 19 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд Хууль зүйн яамнаас “Валютын зохицуулалтын тухай” хуульд 2009 онд шинжилгээ хийн давхардал 3, зөрчил 18, хийдэл 30 гарч байна уг хуулийг нэн даруй шинэчлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргаж байсан боловч одоог хүртэл шинэчлэгдээгүй байна.
2. Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэндээ өэлтэй, эдийн засагтаа үр өгөөжтэй банк санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхээр, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлд валютын нэгдсэн зохицуулалтыг бий болгох, хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор валютын зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулахаар тусгасан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Валютын зохицуулалтын тухай хуулийг боловсронгуй болгох шаардлагатай байна.
3. Монголбанкны зүгээс 1997 онд батлагдсан Статистикийн тухай хуулийн хүрээнд Үндэсний статистикийн хорооны зөвлөлөөс гаргасан хүснэгтээр гадаад худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, гадаадын хөрөнгө оруулалттай, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүсэлт гарган холбогдох мэдээллийг авч байна. Энэ нь хэдийгээр төлбөрийн тэнцлийн чанарыг сайжруулахад дэмжлэг болж байгаа хэдий ч гадаад хөрөнгө оруулалтын позицийн статистикийг гаргахад хамрах хүрээ дутагдалтай хэвээр байна. Одоогийн мөрдөгдөж буй “Валютын зохицуулалтын тухай” хуулийн 2001 оны нэмэлт, өөрчлөлтөөр 14 дүгээр зүйлийн 6-д “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрсдийн гадаадаас авсан валютын зээлийг Монголбанкинд бүртгүүлнэ” гэж заасан хэдий ч бусад төрлийн тухайлбал, гадаад шууд хөрөнгө оруулалт, богино хугацааны санхүүгийн хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгө худалдан авалт, худалдаа үйлчилгээ зэрэг гадаад гүйлгээний мэдээг төрийн эрх бүхий байгууллагад гаргаж өгөхөөр тусгагдаагүй байна. Иймд гадаад секторын статистикийн мэдээг боловсруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна.
4. Төв банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-д “Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төгрөг нь өөрийн нэрлэсэн дүнгээрээ Монгол улсын нутаг дэвсгэрт бүх төлбөр тооцоонд хэрэглэгдэх төлбөрийн хууль ёсны хэрэгсэл мөн”,

Иргэний хуулийн 217 дүгээр зүйлийн 217.1-д “Мөнгөн төлбөрийн үүргийг Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр гүйцэтгэнэ”, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.” гэж тус тус заасан. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс дээрх хууль, эрх зүйн актуудыг хэрэгжүүлэх зорилгоор хяналт шалгалтыг явуулж байгаа хэдий ч хуулийн заалт, ялангуяа хуулийн заалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо сул байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангах эрх зүйн зохицуулалт болж чадахгүй байна. Иймээс хариуцлагын тогтолцоог чангатгах шаардлагатай байна.

5. Инфляцийн түвшин нам байхад төгрөгийн ам.доллартай харьцах ханш огцом суларч байгаа нь ард, иргэдийн төгрөгт итгэх итгэлийг бууруулж, албан бус долларжилтыг бий болгон ам.долларыг “шүтэх” нийгмийн сэтгэл зүй, хэрэглээ байсаар байна. Эдийн засагт долларын зохиомол эрэлт үүсгэж төгрөгийн ханш үргэлжлэн сулрахад хүргэж, улмаар төгрөгийн орлоготой, ам.долларын зарлагатай иргэдийн бодит орлогыг бууруулах, гадаад валютын албан нөөцийг бууруулах дарамтыг улам бүр нэмэгдүүлж байна. Иймд төгрөгийн ханшийг сулрахад нөлөөлж буй хүчин зүйлийг хязгаарлаж, Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгт итгэх итгэлийг бэхжүүлэн төгрөгийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааны түвшинг хамгаалах, банк, санхүүгийн системийн чадавхийг сайжруулах үүднээс зохицуулалтыг тодорхой болгох, хариуцлагыг нэмэгдүүлэх заалтыг Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулах шаардлагатай байна.
6. Манай орны банк, санхүүгийн салбарт хоёр өндөрлөгтэй зохицуулалтын загварыг хэрэглэх нь оновчтой гэж үзэж, “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийг 2005 онд баталсан. Санхүүгийн зохицуулах хороо /цаашид СЗХ гэх/ шинээр байгуулагдсанаар арилжааны банкуудыг Монголбанк, банкны бус санхүүгийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хороо зохицуулах тогтолцоог бий болгосон. Энэ шийдвэртэй холбогдуулан Монголбанкны Хяналт шалгалтын газрын Банк бус санхүүгийн байгууллагын хэлтсийн чиг үүрэг /тухайн үеийн нэрээр/ СЗХ-нд шилжихэд валют солих цэгийн /цаашид ВСЦ гэх/ зохицуулалтыг шилжүүлэх асуудал гарч Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичигт ВСЦ-ийн зохицуулалт СЗХ-ны үйл ажиллагааны чиглэлд байхаар тусгаж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2007 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар ВСЦ-ийн хяналт зохицуулалтын эрх үүргийг СЗХ-нд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуульд ВСЦ-ийн зохицуулалт тусгагдаагүй буюу СЗХ-ны зохицуулалтын хүрээнд хамаардаггүй, ВСЦ-ийн хяналт зохицуулалтын эрх үүргийг зөвхөн гурван талын Харилцан ойлголцлын санамж бичгээр СЗХ-ны үйл ажиллагааны

чиглэлд байхаар тусгагдсан, харин “Валютын зохицуулалтын тухай”<sup>1</sup> хуулиар валютын зохицуулалт Монголбанкны бүрэн эрхэнд хамарагдахаар тусгасан ч Төв банк /Монголбанк/-ны хуулиар Монголбанкны эрхлэх үйл ажиллагаанд тусгаагүй байна. Иймээс банкнаас гадуурх валютын захын үйл ажиллагааны зохицуулалтын эрх зүйн орчинг тодорхой болгох шаардлагатай байна.

7. Монгол улсын нийгэм, эдийн засагт тулгарч буй санхүүгийн хямралыг даван туулахад санхүүгийн зах зээл, банкны системийн тогтвортой байдал, үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд валютын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, гадаад валютын ханшийн огцом хэлбэлзэл, төгрөгийн ханшийн сулралтыг тогтоон барих үүднээс банкнаас гадуурх валютын захын үйл ажиллагааг цэгцлэх шаардлагатай байна. Банкнаас гадуурх валютын захын үйл ажиллагааг хяналттай болгож, тэдгээрийн гадаад бэлэн валютын арилжааны мэдээг валютын захын тайлан, мэдээнд тусгадаг болгож, валютын захын энэ хэсгийг мэдээлэх, тайлагнах тогтолцоонд нэн даруй хамруулах шаардлагатай байна. Ингэснээр гадаад валютын дотоодын захад оролцогчид шийдвэр гаргахад хэрэглэгдэх мэдээллийн урсгалыг чанаржуулж, гадаад валютын дотоодын захын талаарх мэдээллийн нэгдсэн систем байгуулах, валютын нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

## **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийн макро эдийн засгийн бодлогын суурь нь хөрөнгийн чөлөөтэй урсгал, зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэм болон төрийн мөнгөний бодлогын бие даасан байдал бөгөөд зохицуулах харилцаа нь эдийн засгийн харьят хоорондын болон тэдгээрээс харьят бустай хийх валютын гүйлгээ, валютын дотоодын захын зохицуулалт төдийгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэхтэй холбоотой харилцаа байна.

### **1. Ерөнхий бүтэц**

Шинэчилсэн найруулгын төсөл нь 7 бүлэг 21 зүйлтэй.

Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл

Хоёрдугаар бүлэг: Валютын захын зохицуулалт

Гуравдугаар бүлэг: Гадаад гүйлгээ, төлбөр тооцооны зохицуулалт

Дөрөвдүгээр бүлэг: Тайлагнах, мэдээлэх

<sup>1</sup> “Валютын зохицуулалтын тухай” хуулийн 8.1. дэх зүйлд “Монголбанк улсын хэмжээнд валютын гүйлгээг зохицуулж, хэрэгжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9.1. дэх зүйлд “Валют худалдах, худалдан авах, хадгалах, зээлдэх, шилжүүлэх, байршуулах, барьцаалах, улсын хилээр оруулах, гаргахтай холбоотой үйл ажиллагааг валютын гүйлгээ гэнэ”, 17 дахь заалтад “Монголбанк нь валютын зохицуулалтын тухай хууль тогтоомжийн биелэлтийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн төрөл, хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах, валютын гүйлгээтэй холбоотой баримт, сэлтийг шалгах, валютын гүйлгээ, гадаад төлбөр тооцооны ажиллагааны талаарх бүртгэл, тайлан мэдээний үнэн зөвийг шалгах зэрэг үндсэн үүрэгтэй байна.

Тавдугаар бүлэг: Валютын зохицуулалтын талаар төрийн байгууллагуудын хэрэгжүүлэх бүрэн эрх

Зургаадугаар бүлэг: Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт

## 2. Зохицуулах харилцаа

Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, эдийн засгийн харьяат хоорондын болон тэдгээрээс харьяат бустай хийх валютын бүх төрлийн гүйлгээний эрх зүйн зохицуулалт, валютын дотоодын захын дэд бүтэц, мэдээллийн урсгалыг тодорхойлох, ханшийн механизм ажиллах, зах зээлийн мэргэжлийн оролцогчдын шударга өрсөлдөөнийг хангах нөхцөлийг бүрдүүлэх замаар валютын зах үр ашигтай ажиллах эрх зүйн орчныг бий болгох, эрх бүхий төрийн байгууллагуудын дээрх харилцаанд оролцох эрх зүйн байдал, төрөөс явуулах хяналт, шалгалт, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

## 3. Хамрах хүрээ

Хуулийн төсөл нь Монгол Улсын эдийн засгийн харьяат болон харьяат буст хамаарна. Эдийн засгийн харьяат гэдэгт олон улсын стандартын дагуу дараах хуулийн этгээдүүд орно. Үүнд:

- МУ-ын нутаг дэвсгэр дээр оршин суугч Монгол улсын иргэд,
- Гадаад оронд 1 жил хүртэл хугацаагаар түр оршин суугч Монгол улсын иргэд,
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр 1 жилээс дээш хугацаагаар оршин суугч гадаадын иргэд,
- Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, Засгийн газрын байгууллага, төрийн бус байгууллага ба тэдгээрийн салбар, төлөөлөгчдийн газар,
- Монгол Улсаас гадаад орнуудад суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүд,
- Гадаад орнуудад сурч байгаа болон гадаадад урт болон богино хугацаагаар эмчлүүлж буй Монгол улсын иргэд

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал**

Хуулийн төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар бий болно:

- Валютын эдийн засгийн харилцааг оновчтой зохицуулж өгснөөр зах зээлд оролцогчдын үйл хөдлөл оновчтой байх, зах зээлийн механизм үр ашигтай ажиллах, эдийн засаг дахь төрийн оролцоо зохистой байх боломжийг бүрдүүлнэ.

- Хөрөнгийн чөлөөт урсгал, зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэмийн талаарх заалтуудыг хуульд тодорхой тусгаснаар макро эдийн засгийн бодлогын сонголтыг тодорхой болгож, төрийн мөнгөний бодлогын бие даасан байдлыг дээшлүүлэх, санхүүгийн салбарын тогтвортой байдалд дэмжлэг болно.
- Гадаад секторын статистик, валютын дотоодын захын ханш, валютын арилжааны мэдээний хамрах хүрээ, чанаар, давтамжийг сайжруулах боломжтой болно. Энэхүү мэдээллийн урсгал сайжирснаар макро эдийн засгийн бодлого боловсруулагч, зах зээлд оролцогчдын үйл хөдлөл оновчтой байх, улмаар зах зээл үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хөрөнгийн дотогшлох болон гадагшлах ихээхэн хэмжээний урсгал, онцгой байдал үүссэн нөхцөлийн зохицуулалтын арга хэмжээ авах боломжийг хуульд тусгаж өгснөөр макро эдийн засгийн гадаад болон дотоод тэнцлийн тогтвортгүй байдал үүсэх, улмаар эдийн засгийн хямралд орохоос урьдчилан сэргийлэх боломжтой болно.
- Валютын дотоодын захын дэд бүтцийг бий болгон зах зээлийн бус сөрөг хүчин зүйлсийн нөлөөллийг хязгаарлаж, үнийн механизм ажиллах нөхцөлийг бүрдүүлснээр валютын захын үр ашигийг нэмэгдүүлнэ. Энэ нь эдийн засаг дахь үнийн зохицуулалт үр дүнтэй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж, улмаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлнэ.
- Валютын биржийн болон биржийн бус захын үйл ажиллагааны эрх зүйн орчин сайжирч, үйл ажиллагаа нь хяналттай, боловсронгуй болж, тухайн захын оролцогчдын санхүүгийн хариуцлага дээшилж, валютын ханшийн “зохиомол” өсөлтийг арилгана.
- Бэлэн валютын урсгалын мэдээллийг сайжруулснаар валютын ханшийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Валютын зохицуулалтын хуулийн төслийг практик шаардлагад нийцүүлэн боловсруулснаар хариуцлагын тогтолцоо чангарч хуулийн хэрэгжилт сайжрах болно.
- Валютын зохицуулалтын талаарх хууль эрх зүйн орчинг шинэчлэх зорилтыг биелүүлж, эдийн засгийн одоогийн нөхцөл байдал, ойрын хугацааны хандлагад нийцсэн хуультай болно.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулттай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Хуулийн төсөлтэй холбогдон Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Валютын зохицуулалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төлбөр тооцоог үндэсний мөнгө тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулна.